

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ГИШҮҮН ОРНЫ ТАНИЛЦУУЛГА



Монгол Улс: 2020 онд батлагдсан зээл, буцалтгүй тусламж, хувьцааны хөрөнгө оруулалт, техникийн туслалцаа, худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт, бичил санхүүгийн хөтөлбөрийн батлагдсан дүн (сая \$)^a

Нэр төрөл	Засгийн газрын	Хувийн хэвшлийн	Нийт
Зээл	371.28	15.12	386.40
Буцалтгүй тусламж	17.00	—	17.00
Техникийн туслалцаа ^b	15.57	0.37	15.94
Худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт болон бичил санхүү ^c	—	19.75	19.75
Нийт	403.85	35.24	439.09

— = тэг

Тайлбар:

^a "Батлагдсан" гэдэг нь АХБ-ны Захирлуудын зөвлөл буюу Удирдлагаас баталж, Зээлдэгч, хүлээн авагч, хөрөнгө оруулалт авч буй тал болон АХБ гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан санхүүжилтийг хэлнэ.

Буцалтгүй тусламж ба техникийн туслалцаанд АХБ-ны захиран зарцуулах хамтарсан санхүүжилтийн дүн орсон.

^b Дүнг бүхэлдсэн тул нийлбэр зөрж болно.

^c Бус нутгийг хамарсан техникийн туслалцааны санхүүжилтийг хөгжиж буй гишүүн орноор задлах боломжтой тохиолдолд улс тус бүрээр салгаж тооцсон.

^d Эргэн төлөлтийг дахин зарцуулах хувийн хэвшлийн хөтөлбөрийн АХБ-наас санхүүжүүлэх дүн; үүнээс \$14.62 сая нь богино хугацааны санхүүжилт болно.

Монгол Улс: Зээл, буцалтгүй тусламж, хувьцааны хөрөнгө оруулалт, ТТ, худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт, бичил санхүүгийн хөтөлбөрийн батлагдсан санхүүжилт, өссөн дүнгээр^{a, b, c, d}

Салбар	Тоо	Нийт дүн (сая \$) ^e	% ^f	COVID-19-ийн эсрэг хариу арга хэмжээ (сая \$) ^g
Төсөл, ТТ	432	3,731.60	95.67	177.50
Хөдөө аж ахуй, байгалийн баялаг ба орон нутгийн хөгжил	57	240.60	6.17	15.95
Боловсрол	32	183.28	4.70	—
Эрчим хүч	41	457.01	11.72	—
Санхүү	57	419.17	10.75	0.07
Эрүүл мэнд	49	304.80	7.81	34.40
Худалдаа, аж үйлдвэр	18	208.64	5.35	0.21
Мэдээлэл, харилцаа холбооны технологи	4	81.85	2.10	0.07
Салбар хоорондын	7	22.03	0.56	—
Төрийн секторын удирдлага	69	696.42	17.85	126.80
Тээвэр	55	691.92	17.74	—
Ус хангамж, хотын бусад дэд бүтэц ба үйлчилгээ	43	425.89	10.92	—
Худалдаа, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилт ба бичил санхүү^h	653	168.86	4.33	11.13
Санхүү	330	84.43	2.16	5.56
Аж үйлдвэр ба худалдаа	323	84.43	2.16	5.56
Нийт	1,085	3,900.46	100.00	188.63

— = тэг, ХБГО = хөгжиж буй гишүүн орон, ТТ = техникийн туслалцаа.

^a Буцалтгүй тусламж ба ТТ-ны дүнд АХБ-наас захиран зарцуулж буй хамтарсан санхүүжилт орсон.

^b Засгийн газрын болон хувийн хэвшлийн зээл, ТТ-г оруулж тооцсон.

^c Баталгаажсан дүнг үндсэн салбарын хүрээнд тайлагнасан.

^d Бус нутгийг ТТ-ны санхүүжилтийг ХБГО-ор задлах боломжтой тохиолдолд улс тус бүрээр салгаж тооцсон.

^e Дүнг бүхэлдсэн тул нийлбэр зөрж болно.

^f Эргэн төлөлтийг дахин зарцуулах хувийн хэвшлийн хөтөлбөрийн АХБ-наас санхүүжүүлэх дүн; үүнээс \$121 сая нь богино хугацааны санхүүжилт болно.

Монгол Улс цар тахлын сөрөг нөлөөг даван туулж, урт хугацаандаа тогтвортой, хүртээмжтэй хөгжихөд нь АХБ гучин жилийн хамтын ажиллагааны туршлагадаа тулгуурлан засгийн газар болон хувийн хэвшилд санхүүгийн болон мэдлэгийн дэмжлэг үзүүлнэ.

МОНГОЛ УЛС

Коронавируст халдвар (COVID-19) дэгдэхээс өмнө 2017-2020 онд гадаад эрэлт нэмэгдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт сэргэсэнтэй холбоотойгоор Монгол Улсын эдийн засаг дунджаар 5.9%-ийн өсөлттэй байсан.

Монгол Улсын Засгийн газар COVID-19-ийн халдварыг тогтоон барих шуурхай арга хэмжээ авсан хэдий ч эдийн засагт хүндрэл үүсч, дотоодын нийт бүтээгдэхүүн 2020 онд 5.3 хувиар агшсан.

Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь 1991 оноос хойш өнөөг хүртэл Монгол Улсын хамгийн гол олон талт хөгжлийн түнш байсаар ирсэн бөгөөд зах зээлийн эдийн засаг бүхий, дундаж орлоготой улс орон болон хөгжихөд нь чухал үүрэг гүйцэтгэсэн.

АХБ 1991 оноос хойш Монгол Улсад нийт 3 тэрбум ам.долларын засгийн газрын зээл, 182.1 сая ам.долларын хувийн хэвшлийн зээл, 335.7 сая ам.долларын буцалтгүй тусламж болон 187.1 сая ам.долларын техникийн туслалцаа (ТТ)-ны санхүүжилтийг тус тус баталжээ.

Монгол Улсад олгосон зээл, буцалтгүй тусламжийн зарцуулалт 2.42 тэрбум ам.долларт хүрсэн ба энэ нь энгийн болон хөнгөлөлттэй ердийн хөрөнгийн эх үүсвэр, Азийн хөгжлийн сан болон бусад тусгай сангийн эх үүсвэрээс санхүүжсэн байна.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ДЭМЖЛЭГТЭЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

2020 онд АХБ-наас Монгол Улсын COVID-19-ийн бэлэн байдал, хариу арга хэмжээг сайжруулах, цар тахлын үед гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүнсний аюулгүй байдлын эрсдлийг удирдахад дэмжлэг үзүүлэх зорилгоор шуурхай тусламжийг олгосон. Мөн Ази, Номхон далайн гамшгаас хамгаалах сангийн



эх үүсвэрээс хоёр яаралтай буцалтгүй тусламжийг санхүүжүүлсэн.

100 сая ам.долларын санхүүжилттэй АХБ-ны КОВИД-19 цар тахлын эсрэг шуурхай арга хэмжээний хөтөлбөр нь цар тахлын улмаас эрүүл мэндийн салбар болон эдийн засагт учирсан сөрөг нөлөөг бууруулах, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх, халдвар хамгааллын болон шинжилгээний чадавхийг сайжруулахад Засгийн газарт дэмжлэг үзүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд эмзэг бүлгийн эмэгтэй ажилтнуудыг, тэр дундаа бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг нийгмийн хамгааллын болон ажлын байр хадгалахад чиглэсэн Засгийг газрын хөтөлбөрт хамруулсан.

АХБ-наас эмнэлгийн хүчин чадал, халдвар хамгааллыг сайжруулах зорилгоор одоо хэрэгжиж буй эрүүл мэндийн салбарын төсөлд 30 сая ам.долларын нэмэлт санхүүжилт олгосны зэрэгцээ цар тахалд өртсөн эмзэг бүлгийн иргэдэд тэтгэмж олгоход зориулж 26.4 сая ам.долларын санхүүжилтийг баталсан.

Монгол Улсын тогтвортой, хүртээмжтэй хөгжлийг дэмжих АХБ-ны үйл ажиллагаа 2020 онд үргэлжилсэн. Ядуурлыг бууруулах Японы сан

(ЯБЯС)-гийн 2 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжих хүртээмжтэй боловсролыг дэмжих төсөл нь сургууль, цэцэрлэгт хамрагдалтыг сайжруулна. 100 сая ам.долларын зээл болон 3 сая ам.долларын буцалтгүй тусламжаар дэлхийд томоохонд тооцогдох 125 мегаваттын хүчин чадал бүхий дэвшилтэт технологийн цэнэгт хураагуурын системийг Монголд анх удаа суурилуулна. Монгол орны эрс тэс, хүйтэн уур амьсгалд тохирсон, сэргээгдэх эрчим хүчээр бүрэн цэнэглэгдэх тус систем нь 2025 оноос эхлэн жил тутам 842,039 тонн нүүрстөрөгчийн хийн ялгарлаас сэргийлэх юм.

Улаанбаатар хотын үйлчилгээг сайжруулж, гэр хорооллыг хөгжүүлэх АХБ-ны 43.65 сая ам.долларын төслийн хүрээнд барих авто зам, үерийн далан, цэвэр, бохир усны болон цахилгааны шугам, мөн нийтийн байгууламжийн үр өгөөжийг нийт 840,000 оршин суугч хүртэнэ. Нийслэлийн агаарын чанар болон нийгмийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор АХБ-наас 60 сая ам.долларын санхүүжилт олгосон. Мөн дөрвөн хотын хатуу хог хаягдлын менежмент, дахин боловсруулалтыг сайжруулах ЯБЯС-

гийн 2 сая ам.долларын буцалтгүй тусламжийг тус банк хэрэгжүүлж байна.

Хөдөө аж ахуйг дэмжих ажлын хүрээнд үр ашигтай, уур амьсгалд тэсвэртэй усалгааны системийг нэвтрүүлэх 40 сая ам.долларын зээл, ЯБЯС-гийн 2 сая ам.долларын буцалтгүй тусламжийг АХБ олгосон нь 3,458 ногоочин өрхөд ашиг тусаа өгч байна.

Монгол Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх Замын-Үүдийн чөлөөт бүсийг хөгжүүлж, ашиглалтад оруулахад зориулж АХБ 30 сая ам.долларын зээлийг баталсан.

АХБ-наас боловсруулан гаргадаг мэдлэгийн бүтээгдэхүүнийг бодлогын түвшинд ач холбогдолтой байлгах үүднээс “Ажиллалт ба Санал” бодлогын зөвлөмжийн цувралыг үргэлжлүүлж, “Ажиллах хүчин дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоог ижил түвшинд хүргэснээр Монгол Улсын үрт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмжих нь” дугаарыг хэвлэн гаргасан. Түүнчлэн улс орны хөгжлийн сорилт, боломжийг хөндсөн бодлогын зөвлөмж бүхий номыг эрхлэн гаргаж нийтийн хүртээл болгосон.

Монгол Улс: Засгийн газрын болон хувийн хэвшлийн үйл ажиллагааны үнэлгээний дүн, 2011–2020

	Хөндлөнгийн үнэлгээ хийгдсэн төсөл, хөтөлбөрийн тоо	Үнэлгээний дүн		
		Маш амжилттай ба амжилттай	Амжилт багатай	Амжилтгүй
Засгийн газрын үйл ажиллагаа	14	8	6	—
Хувийн хэвшлийн үйл ажиллагаа	4	1	3	—

— = тэг, ХҮГ = Хөндлөнгийн үнэлгээний газар

Тайлбар: Зөвхөн ХҮГ-аас магадлан баталгаажуулж эсхүл үнэлгээ хийсэн Монгол Улсын засгийн газрын болон хувийн хэвшлийн төслүүдийн тоо болон үнэлгээний дүнг харуулсан. Үүнд 2010 оны 7-р сарын 1-нээс 2020 оны 6-р сарын 30-ныг хамрах хугацаанд магадлан баталгаажуулж эсхүл үнэлгээ хийж, АХБ-наас танилцуулсан төслийн хаалтын тайлан, жилийн үнэлгээний дэлгэрэнгүй тайланг хамруулсан. Монгол Улстай холбоотой үнэлгээг эндээс харна уу.

Эх сурвалж: ХҮГ-ын төслийн үнэлгээний тайлангийн мэдээллийн сан (2020 оны 12-р сарын 31-ний байдлаар).

Монгол Улс: Хамтарсан санхүүжилттэй төслүүд, 2016 оны 1-р сарын 1-нээс – 2020 оны 12-р сарын 31 хүртэл

Хамтарсан санхүүжилт	Төслийн тоо	Дүн (сая \$)
Засгийн газрын ^a	51	438.62
Зээл	6	298.29
Буцалтгүй тусламж	17	112.88
Техник тусалцаа	29	27.45
Хувийн хэвшлийн	2	122.20

^a Нэгээс олон хамтарсан санхүүжилтийн эх үүсвэртэй төслийг нэгээр тоолсон.

Монгол Улс: Ердийн хөрөнгийн эх үүсвэртэй хувийн хэвшлийн санхүүжилт, бүтээгдэхүүнээр

	2020 он	2016-2020 он
Гарын үсэг зурсан хэлцлийн тоо (ЕХЭҮ)	1	4
Гарын үсэг зурсан хэлцлийн тоо (хөтөлбөрүүд)	35	426
Дүн (сая \$)		
Зээл	15.12	62.10
Хувьцааны хөрөнгө оруулалт	—	—
Батлан даалт	—	—
Худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн хөтөлбөр болон бичил санхүүгийн хөтөлбөр	19.75	91.48
Нийт	34.87	153.58

— = тэг, ЕХЭҮ = ердийн хөрөнгийн эх үүсвэр.

Монгол Улс: Засгийн газрын зээл ба буцалтгүй тусламжийн багцын гүйцэтгэлийн чанарын үзүүлэлтүүд, 2019-2020

Одоо хэрэгжиж буй тусламжийн тоо ^a (2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар)	2019 (сая \$)	2020 (сая \$)
Гэрээлсэн дүн ^{b, c}	134.48	160.10
Зарцуулалт ^b	261.58	330.07
Одоо хэрэгжиж буй буцалтгүй тусламжийн тоо ^{a, d} (2020 оны 12-р сарын 31-ний байдлаар)		
	2019 (сая \$)	2020 (сая \$)
Гэрээлсэн дүн ^{b, c, d}	0.95	5.08
Зарцуулалт ^{b, d}	0.75	7.28
Хэрэгжилтийн явцад бэрхшээл тулгарсан төслийн эзлэх хувь (%) (2020 оны 12-р сарын 31-ний байдлаар)		11

^a Баталгаажсан төслүүдийн дунд суурилсан.

^b Хэрэгжиж дууссан ч тухайн жилд гэрээ байгуулагдаж, зарцуулалт хийгдсэн зээл/буцалтгүй тусламжийг оруулж тооцсон.

^c Бодлогод суурилсан, үр дүнд суурилсан болон санхүүгийн зуучлал/дамжуулан зээлдэх зээл/буцалтгүй тусламжийг оруулаагүй.

^d Зөвхөн Азийн хөгжлийн сан болон АХБ-ны бусад тусгай сангуудын санхүүжилтийг оруулж тооцсон.

Монгол Улс: Зээл, буцалтгүй тусламж, ТТ-ны төслүүдэд худалдан авалтын гэрээний эзлэх хувь

	2019		2020		Өссөн дүнгээр (2020 оны 12-р сарын 31-ний байдлаар)	
	Дүн (сая \$)	Эзлэх %	Дүн (сая \$)	Эзлэх %	Дүн (сая \$)	Эзлэх %
Нэр, төрөл						
Бараа, ажил ба дагалдах үйлчилгээ	198.15	1.40	282.82	1.24	1,565.16	0.72
Зөвлөх үйлчилгээ	9.67	1.28	12.04	1.64	64.43	0.46
Нийт худалдан авалт	207.82	1.39	294.86	1.25	1,629.59	0.71

Монгол Улс: АХБ-ны зээл ба буцалтгүй тусламжийн төслүүдэд бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн гэрээний дүнгээр эхний 5-д орох ханган нийлүүлэгч/гүйцэтгэгч, 2016 оны 1-р сарын 1-нээс – 2020 оны 12-р сарын 31

Гүйцэтгэгч/Ханган нийлүүлэгч	Салбар	Гэрээний дүн (сая \$)
ВAMEД Инженеринг	HLT	31.45
Комфорт Импекс ХХК	WUS	10.94
Эйч-Кэй-Би Интернэйшнл Холдинг ХХК	IND, TRA	8.00
Ай-Ти Зон ХХК	EDU, ENE, FIN, HLT, PSM, TRA, WUS	7.54
Мэдимпекс Интернэйшнл ХХК	ANR, EDU, HLT, IND	6.88
Бусад		754.84
Нийт		819.65

ANR = хөдөө аж ахуй, байгалийн баялаг ба орон нутгийн хөгжил; EDU = боловсрол; ENE = эрчим хүч; FIN = санхүү; HLT = эрүүл мэнд; IND = аж үйлдвэр ба худалдаа; PSM = төрийн салбарын удирдлага; TRA = тээвэр; WUS = ус хангамж, хотын бусад дэд бүтэц ба үйлчилгээ.

Монгол Улс: АХБ-ны зээл ба буцалтгүй тусламж, ТТ-ны төслүүдийн хүрээнд байгуулагдсан зөвлөх үйлчилгээний гэрээний дүнгээр эхний 5-д орох зөвлөхүүд, 2016 оны 1-р сарын 1-нээс – 2020 оны 12-р сарын 31

Зөвлөх	Салбар	Гэрээний дүн (сая \$)
Монконсалт ХХК	ANR, TRA	2.36
БДО Аудит ХХК (Монгол)	PSM	2.31
Ай-Ти Зон ХХК	HLT	1.55
Татах Хүч ХХК	EDU, IND	1.40
Ричвэлл Инженеринг ХХК	WUS	1.10
Хувь зөвлөхүүд		20.46
Бусад		15.16
Нийт		44.33

ANR = хөдөө аж ахуй, байгалийн баялаг ба орон нутгийн хөгжил; EDU = боловсрол; HLT = эрүүл мэнд; IND = аж үйлдвэр ба худалдаа; PSM = төрийн салбарын удирдлага; TRA = тээвэр; WUS = ус хангамж, хотын бусад дэд бүтэц ба үйлчилгээ.

ХУВИЙН ХЭВШЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад түлхэц өгөх зорилгоор АХБ хувийн хэвшлийн болон санхүүгийн зуучлагч байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. 2020 онд АХБ өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс нийгэм, эдийн засгийн дэд бүтэц, санхүүгийн салбар болон хөдөө аж ахуйн бизнесийн 38 хэлцэлд нийт 1.4 тэрбум ам.долларыг шууд зээл олгох болон дүрмийн санд хөрөнгө оруулахаар баталсан. Мөн АХБ арилжааны болон бусад хөнгөлөлттэй эх үүсвэрээс хамтарсан санхүүжилтийг татан оролцуулдаг. Тухайлбал, 2020 оны байдлаар 1.9 тэрбум ам.долларын урт хугацааны хамтарсан санхүүжилт, мөн худалдаа ба нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн хөтөлбөр (ХНССХ) болон бичил санхүүгийн хөтөлбөрөөр дамжуулан 3.3 тэрбум ам.долларын хамтарсан санхүүжилтийг бүрдүүлсэн. АХБ-ны өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс хувийн хэвшилд олгосон болон олгохоор баталсан санхүүжилт 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар 14.3 тэрбум ам.долларт хүрсэн байна.

2020 онд АХБ Монгол Улсад улаан буудайн нийлүүлэлтийн сүлжээний хөрвөх чадварыг дэмжих төсөл болон сүү, сүүн бүтээгдэхүүний өртгийн сүлжээг дэмжих төсөлд зориулж нийт

15.1 сая ам.долларын санхүүжилтийг өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс олгохоор шийдвэрлэсэн. АХБ-ны өөрийн хөрөнгийн эх үүсвэрээс Монгол Улсын хувийн хэвшилд олгосон санхүүжилт 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар 69.5 сая ам.доллар байгаа нь АХБ-ны нийт хувийн хэвшлийн санхүүжилтийн 0.5 хувьтай тэнцэж байна.

ТҮНШЛЭЛ

АХБ ба Монгол Улсын Засгийн газар нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн сан (ЮНИСЕФ), Европын Хөрөнгө Оруулалтын Банк, Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Билл, Мелинда Гейтсийн сан, Цэвэр эрчим хүчний санхүүжилтийн түншлэлийн механизм, Цахим Ази ба Мэдлэгийн түншлэлийн сан, Санхүүгийн салбарын хөгжлийн түншлэлийн сан, Азийн сан, НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр болон Дэлхийн Банк зэрэг байгууллагуудтай хамтран ажилладаг. Үйл ажиллагааны уялдаа холбоог хангасан нь КОВИД-19-ийн үр дагаврыг хязгаарлахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

АХБ нь Монгол Улс дахь үйл ажиллагаагаа чиглүүлэх зорилгоор Иргэний нийгмийн зөвлөлдөх хороог

байгуулж, түншлэлийн шинэ стратегийг боловсруулах ажлын хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудтай 9 удаагийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, одоо хэрэгжиж буй төслүүдийн талаар нээлттэй яриа хэлэлцээ хийж байна.

САНХҮҮЖИЛТИЙН ТҮНШЛЭЛ

Санхүүгийн түнш байгууллагууд, засгийн газрууд, харьяа агентлагууд, олон талт санхүүгийн болон бизнесийн байгууллагууд АХБ-ны төслүүдийг хамтран санхүүжүүлж, дэмжин оролцдог. Энэхүү санхүүжилтийг албан ёсны зээл, буцалтгүй тусламж, ТТ, арилжааны эх үүсвэр бүхий зээл, эрсдэл шилжүүлэх хэлцэл, зэрэгцээ зээл, хөрөнгө оруулалт, баталгаа, батлан даалт зэрэг хувийн хэвшлийн хамтарсан санхүүжилт хэлбэрээр болон АХБ-ны ХНССХ болон Бичил санхүүгийн хөтөлбөрийн хүрээнд хийж байна.

АХБ 1994 онд Монгол Улсад хамтарсан санхүүжилтийн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш засгийн газрын 47 хөрөнгө оруулалтын төсөлд 513.72 сая ам.доллар, 66 ТТ-ны төсөлд 60.1 сая ам.долларын хамтарсан санхүүжилтийг баталсан. Харин Монгол Улсын хувийн хэвшлийн 5 хөрөнгө оруулалтын төсөлд 188.05 сая ам.доллар, 1 ТТ-ны төсөлд 0.22 сая ам.долларын хамтарсан санхүүжилт олгожээ.

Монгол Улс 2020 онд хөрөнгө оруулалтын 3 төсөлд зориулж Азийн Дэд Бүтцийн Хөрөнгө Оруулалтын Банк, Европын Хөрөнгө Оруулалтын Банк болон Дэлхийн Банкнаас нийт 123.65 сая ам.долларын хамтарсан санхүүжилт; Өндөр Түвшний Технологийн Сан, ЯБЯС-аас 7 хөрөнгө оруулалтын төсөлд нийт 14.5 сая ам.долларын буцалтгүй тусламж хүлээн авсан.

2016 оны 1-р сарын 1-ээс 2020 оны 12-р сарын 31-ний хооронд хэрэгжсэн хамтарсан санхүүжилттэй төслүүдийн хураангуйг: www.adb.org/countries/mongolia/cofinancing.

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

АХБ хөгжиж буй гишүүн орнууддаа хэрэгжиж буй зээл, буцалтгүй тусламж болон ТТ-ны төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд бараа, ажил, зөвлөх үйлчилгээний гэрээг санхүүжүүлэхэд олон тэрбум доллар зарцуулдаг. Гэрээний дийлэнхийг олон улсын өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын аргаар хийдэг ба үүнд АХБ-ны гишүүн орнуудын компани болон хувь хүн нээлттэй оролцох боломжтой байдаг.

АХБ-ны Худалдан авалтын гэрээний эзлэх хувь

Бараа, ажил ба дагалдах үйлчилгээ

Ази, Номхон далайн бүс нутагт АХБ-ны дэмжлэгтэй зээл, буцалтгүй тусламжийн төслүүдийн хүрээнд хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний гэрээний нийт дүн 2019 онд 14.19 тэрбум ам.доллар, 2020 онд 22.79 тэрбум

ам.доллар байв. 1966 оноос хойш өнөөг хүртэл өссөн дүнгээр нийт 216.35 тэрбум ам.долларын 222,415 гэрээ байгуулжээ.

1991 оноос хойш нийт 1.57 тэрбум ам.долларын 3,509 гэрээг Монголын ханган нийлүүлэгч, гүйцэтгэгчидтэй байгуулсан байна.

Зөвлөх үйлчилгээ

Ази, Номхон далайн бүс нутагт АХБ-ны дэмжлэгтэй зээл, буцалтгүй тусламж, ТТ-ны хүрээнд хийгдсэн зөвлөх үйлчилгээний гэрээний нийт дүн 2019 онд 756.72 сая ам.доллар, 2020 онд 732.11 сая ам.доллар байв. 1966 оноос хойш өнөөг хүртэл өссөн дүнгээр нийт 14.13 тэрбум ам.долларын 67,086 гэрээ байгуулжээ.

1991 оноос хойш нийт 64.43 сая ам.долларын 1,624 гэрээг Монголын зөвлөхүүдтэй байгуулсан байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТУУД

КОВИД-19 цар тахлаас өмнө Монгол Улсын макро эдийн засгийн тогтвортой байдал сайжирсан ч цочролд эмзэг хэвээр байна. Эдийн засгийн суурийг өргөжүүлж, төрөлжүүлэх шаардлагатай. Жижиг, дунд үйлдвэрүүд төрөлжилтийг эрчимжүүлэх бөгөөд ялангуяа Монголын хөдөө аж ахуйн өвөрмөц нөөц баялгийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлснээр хүртээмжтэй өсөлтийг хангах боломжтой. Үүний тулд санхүүгийн хүртээмж, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, мөн гадаад зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлэх

бүс нутгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай. Ур чадвартай ажиллах хүч бэлтгэх, хот суурин газрын амьдрах орчныг сайжруулах нь мөн чухал байна. Нийгмийн үйлчилгээний хүртээмж болон үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд бодлогын шинэчлэл хийх, институцийг бэхжүүлэх шаардлагатай. Хотжилт, уул уурхайн салбарын сул зохицуулалт, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас байгаль орчин ноцтой доройтож байгаа тул эдгээр асуудалд анхаарал хандуулах нь чухал байна.

ИРЭЭДҮЙН ЧИГЛЭЛ

АХБ-наас 2021–2024 онд Монгол Улстай хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратеги нь тус улсын КОВИД-19-ийн дараах сэргэлт болон тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг дэмжихэд чиглэх юм. АХБ нь Монгол Улсын эдийн засгийг цар тахлын нөлөөнд тэсвэртэй байхад дэмжлэг үзүүлэх үүднээс засгийн газар, хувийн хэвшилд чиглэсэн үйл ажиллагаа болон мэдлэг солилцох санаачлагуудыг хэрэгжүүлнэ. Мөн иргэдэд өөрийн боломжийг бүрэн ашиглах ур чадвар олгох чиглэлээр засгийн газартай хамтран ажиллаж, төрөлжсөн, байгаль орчинд ээлтэй, нийгмийн бүх давхаргад хүртээмжтэй эдийн засгийг бүрдүүлэхэд туслах болно.

АХБ нь хамтарсан санхүүжилтийн түншлэлээ өргөжүүлж, Монгол Улсын хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай нэмэлт эх үүсвэр, мэдлэг туршлагаар хангана.





МОНГОЛ УЛС БА АХБ

АХБ-ны гишүүнчлэл: 1991 онд гишүүнээр элсэн орсон

Хувь эзэмшил ба саналын эрх

Эзэмшиж буй хувьцааны тоо: 1,596 (нийт хувьцааны 0.015 хувь)
Саналын тоо: 40,710 (нийт гишүүнчлэлийн 0.306 хувь,
бүс нутгийн нийт гишүүнчлэлийн 0.47 хувь)

*Оруулсан нийт хөрөнгө: 22.99 сая ам.доллар

*Хувь нийлүүлсэн хөрөнгө: 1.15 сая ам.доллар

*Америк доллараар илэрхийлсэн дүнг 2020 оны 12-р сарын 31-ний ханшаар тооцсон.

АХБ-нд Монгол Улсыг төлөөлөх захирагч нь **Болдын Жавхлан**, орлогч захирагч нь **Бядраны Лхагвасүрэн** болно.

АХБ-ны Захирлуудын зөвлөлд Монгол Улсыг төлөөлсөн захирлаар **Ноор Ахмед**, орлогчоор **Пол Домингез** ажиллаж байна.

АХБ-ны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчөөр **Павит Рамачандран** ажиллаж байна. 2001 онд байгуулагдсан Суурин төлөөлөгчийн газар нь АХБ ба Засгийн газар, хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцогч талууд болон хөгжлийн түнш хоорондын үйл ажиллагааны уялдааг ханган ажилладаг. Суурин төлөөлөгчийн газраас Монголын талтай бодлогын хэлэлцүүлэг хийх, хамтран хэрэгжүүлэх түншлэлийн стратегийг боловсруулах, холбогдох төсөл хөтөлбөрүүдийг төлөвлөх, одоо хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг удирдан хэрэгжүүлэхийн зэрэгцээ Монгол Улс дахь хөгжлийн асуудлын мэдлэг мэдээллийн төвийн үүргийг гүйцэтгэдэг. Монгол Улсын Засгийн газраас АХБ-тай холбоотой хамтын ажиллагааг Сангийн яам ба Монголбанк хариуцдаг.

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТУХАЙ

АХБ нь бүс нутгийн 49, бүс нутгийн бус 19, нийт 68 гишүүн оронтой олон талт хөгжлийн банк юм. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, хөрөнгө оруулалт, батлан даалт, буцалтгүй тусламж, ТТ зэрэг хэрэгслүүдээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлдэг. 2020 онд нийт 26.9 тэрбум ам.долларын 149 зээл, 293.56 сая ам.долларын 275 ТТ, 1.08 тэрбум ам.долларын 62 буцалтгүй тусламжийг санхүүжүүлсэн. Үүний зэрэгцээ, засгийн газрын болон арилжааны зориулалттай албан ёсны зээл, буцалтгүй тусламж болон Б ангиллын зээл, эрсдэл шилжүүлэх хэлцэл, батлан даалт, зэрэгцээ зээл, хөрөнгө оруулалт, мөн АХБ-ны ХНССХ, Бичил санхүүгийн хөтөлбөрийн хүрээнд нийт 16.41 тэрбум ам.долларын хамтарсан санхүүжилтийг босгожээ. 2016 оны 1-р сарын 1-нээс 2020 оны 12-р сарын 31-ний хооронд АХБ жилд дунджаар 19.69 тэрбум ам.долларын зээл баталж ирсэн. Мөн хугацаанд, АХБ болон тусгай сангуудын эх үүсвэрээс жилд дунджаар 805.5 сая ам.долларын буцалтгүй тусламж, 230.81 сая ам.долларын ТТ үзүүлсэн байна. 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар, хамтарсан санхүүжилтийг эс тооцвол, өссөн дүнгээр нийт 323.17 тэрбум ам.долларын зээлийг 44 орны 3,369 төсөлд, 11.3 тэрбум ам.долларыг 495 буцалтгүй тусламжид, мөн 5.01 тэрбум ам.долларыг бүсийн болон улс дагнасан ТТ-ны буцалтгүй тусламжид олгосон байна.

Тайлбар:

Бүх тоон мэдээлэл, өөрөөр заагаагүй бол, АХБ-ны тооцоолол дээр суурилсан. "\$" тэмдгээр АНУ-ын долларыг илэрхийлсэн.

Өөрөөр заагаагүй бол бүх мэдээлэл нь 2020 оны 12-р сарын 31-ний байдлаарх мэдээлэл болно.

ХОЛБОО БАРИХ ХАЯГ

Азийн Хөгжлийн Банкны Монгол Улс дахь
Суурин төлөөлөгчийн газар
Сүхбаатар дүүрэг-1, Олимпын гудамж-
19А, Шангри-Ла оффис, 18 давхар
Улаанбаатар хот 14241, Монгол Улс
Утас +976 11 313440 / 323507 / 329836

Факс +976 11 311795

adbmnrm@adb.org

www.adb.org/mongolia

АХБ-ны Төв

АХБ-ны өргөн чөлөө-6, Мандалуён хот,
Метро Манила, Филиппин Улс
Утас +63 2 8632 4444
Факс +63 2 8636 2444

Сангийн яам

Засгийн газрын II байр, С.Данзангийн
гудамж 5/1, Улаанбаатар 15160, Монгол
Улс Утас +976 51 264694
Факс +976 51 264908

АХБ-ны онцлох цахим хуудсууд

Азийн Хөгжлийн Банк

www.adb.org

Жилийн тайлан

<https://www.adb.org/documents/series/adb-annual-reports>

Азийн хөгжлийн төлөв

www.adb.org/publications/series/asian-development-outlook

АХБ-ны нэгдсэн мэдээллийн сан

data.adb.org

MONGOLIA
ADB@30



Partnering
Developing
Innovating